



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын "Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 20... тайлан"-ын маягт, нөхөх зааврыг шинэчлэх тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын "Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 20... тайлан"-ын маягт, нөхөх зааврыг хавсралтын дагуу шинэчлэн баталж, 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Сангийн яам /Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Наранцогт/-нд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т үүрэг болгосугай.

3. "Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 20... тайлан"-ын маягт, нөхөх зааврыг шинэчлэн баталсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/143 тоот тушаалыг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.АРИУНЗАЯА

0000056

ҮСХ-ны даргын зөвшөөрснөөр Сэнгийн сайдын ...
оны -р сарын ...-ны өдрийн ... тоот тушаалаар
Батлав.

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 20... ОНЫ ТАЙЛАН

I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар					
Аж ахуйн нэгжийн нэр					
Байршил	1117140325	Нэр			
Аймаг, нийслэл	УХА0561	6097456			
Сум, дүүрэг					
Харьяалах татварын албаны нэр					

1 Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж нь дараа оны 5 дугаар сарын 15-ны дотор ОУИТЭСАА-нд цахим тайлагналын системээр ирүүлнэ.

2 ОУИТЭСАА нь 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний статистикийн хороонд нэгтгэлийг аж ахуйн нэгжээр цахим хэлбэрээр ирүүлнэ.

I.3 Холбоо барих Хүний овог, нэр

Албан тушаал:

Утас: 1

Утас: 2

Цахим хаяг:

I.2 Хариуцлагын хэлбэр (кодыг дугуйлна уу)

Хэлбэр	Код
Хувьцаат компани	10
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	20
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	21
Хоршоо	30
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	41
Төсөвт байгууллага	60
Төрийн бус байгууллага	70
Сан	71
Бусад	80

I.4 Өмчийн хэлбэр (кодыг дугуйлж, өмчийн эзлэх хувийг бичнэ уу)

Төрийн	Хэлбэр	Хувь	Код
	Өмчийн		
Төрийн	Өмчийн оролцоотой		12
	Хамтарсан	%	13
Орон нутгийн	Өмчийн		30
	Өмчийн оролцоотой		31
	Хамтарсан	%	32
Хувийн	Монгол Улсын иргэний		21
	Хамтарсан	%	22
	Гадаад улсын		23

I.5 Үйл ажиллагааны чиглэл (кодыг зааврын хавсралтаас харна уу)

1

2

3

ЭЗҮАСА - 4.0 код

II. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1 Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

МД	Ашигт малтмалын төрөл	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ (га)	Олгосон огноо	Дуусах огноо	Оршин байгаа газар
	А	Б	1	2	3	4
1.1				___/___/___	___/___/___	
1.2				___/___/___	___/___/___	
1.3				___/___/___	___/___/___	
...				___/___/___	___/___/___	

2 Бүтээгдэхүүний олборлолт, борлуулалт, нөхөн сэргээлт

МД	Бүтээгдэхүүний нэр	Код (БУНА)	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хэмжих нэгж	Олборлолт		Борлуулалт	
					Тоо хэмжээ	Зардал (төг)	Тоо хэмжээ	Орлого (төг)
	А	Б	В	Г	1	2	3	4

2.1 Туршилт / хайгуулын үеийн олборлолт, борлуулалт

2.1.1								
2.1.2								
2.1.3								

2.2 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт

2.2.1								
2.2.2								
2.2.3								

2.3 Нөхөн сэргээсэн талбайн мэдээлэл

МД	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн нэр	Талбайн хэмжээ (га)	Нөхөн сэргээлтийн үе шат (техникийн - 1, биологийн - 2)	Зардал (төг)
	А	Б	1	2	3
2.3.1					
2.3.2					
2.3.3					

3 Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг

		Үзүүлэлт	Дүн (төг)
МД	А		1
3.1 Албан татвар			
3.1.1	Аж ахуйн нэгжийн орлогын		
3.1.2	Гаалийн		
3.1.3	Нэмэгдсэн ерттийн		
3.1.4	Автобензин, дизелийн түлшний онцгой		
3.1.5	Автобензин, дизелийн түлшний		
3.2 Төлбөр, хураамж, НД-ын шимтгэл			
3.2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр			
		Улсын зохицууллын дугаар	Тусгай зөвшөөрлийн нэр
3.2.1.1			
3.2.1.2			
3.2.1.3			
3.2.2 Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр			
		Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн нэр
3.2.2.1			
3.2.2.2			
3.2.2.3			
3.2.3	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр		
3.2.4	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр		
3.2.5	Агаарын бохирдлын төлбөр (Зөвхөн нүүрс олборлодог ААН)		
3.2.6	Ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэл		
3.2.7	Гаалийн үйлчилгээний хураамж		
3.2.8	Төрийн өмчийн ногдол ашиг		
3.2.9	Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр		
3.2.10	Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт ногдох орлого		
3.3 Бусад			
3.3.1	Торгууль		
3.3.2	Нөхөн төлбөр		
3.3.3	БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ		
3.3.4	Бусад		

4. Төрийн байгууллагад өгсөн хандин, дэмжлэг

МД	Байгууллагын нэр	Байгууллагын төрөл	Хандив, дэмжлэгийн хэлбэр	Хандив, дэмжлэгийн төрөл	Зорилго	Зориулалт	Дүн (төг)
	А	Б	В	Г	Д	Е	1
4.1							
4.2							
4.3							

Байгууллагын төрөл: Яам - 1, Агентлаг - 2, Аймаг - 3, Нийслэл - 4, Сум - 5, Дүүрэг - 6

Хандив, дэмжлэгийн хэлбэр: Мөнгөн - 1, Мөнгөн бус - 2

Хандив, дэмжлэгийн төрөл: Бэлэг - 1, Хандив - 2, Хариу төлбөргүй үйлчилгээ - 3

Зориулалт: Боловсрол - 1, Соёл - 2, Эрүүл мэнд - 3

5. Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг

МД	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар		Төлбөр					Орон нутгийн торийн өмчийн ногдол ашиг	Бусад			
			Үл хөдлөх эд хоренгийн	Аото тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн	Газрын	Ус ашигласны	Ус бохирдуулсны	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны		Торгууль	Нөхөн төлбөр	Байгаль хамгаалах зардлын 50%-ийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	Бусад
	А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
5.1														
5.2														
5.3														

III. САЙН ДУРЫН МЭДЭЭЛЭЛ

МД	6. Татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс	Дүн (төг)
	А	1
6.1	Хувь хүний орлогоос суугтасан албан татвар	
6.2	Цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж	
6.3	Цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булах тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж	
6.4	Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж	
6.5	Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булах, идэвхийг сулруулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж	
6.6	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглах зөвшөөрлийн хураамж	
6.7	Орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж	
6.8	Нутгийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	
6.9	Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамж	
6.10	Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	
6.11	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний үйлчилгээний хураамж	
6.12	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр	
6.13	Гэрээ, тодорхой нөхцөлөөр хөнгөлсөн, чөлөөлсөн татвар	
6.14	Хөрөнгө оруулалтын зардал	
6.15	Ажиллагчдын сургалт, чадавч бэхжүүлэхэд зориулсан зардал	
6.16	Геологи, хайгуулын зардал	
6.17	Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	
6.18	Гамшгаас хамгаалахад зориулсан зардал	

7. Төрийн бус байгууллага, иргэн, бусад байгууллагад өгсөн хандив, дэмжлэг

МД	Хандив хүлээн авагчийн нэр	Хүлээн авагчийн төрөл	Хандив, дэмжлэгийн хэлбэр	Хандив, дэмжлэгийн төрөл	Зорилго	Зориулалт	Дүн (төг)
	А	Б	В	Г	Д	Е	1
7.1							
7.2							
7.3							
...							

Хүлээн авагчийн төрөл: Төрийн бус байгууллага - 1, Бусад байгууллага - 2, Иргэн - 3
Хандив, дэмжлэгийн хэлбэр: Мөнгөн - 1, Мөнгөн бус - 2

Хандив, дэмжлэгийн төрөл: Бэлгэ - 1, Хандив - 2, Харил төлбөргүй үйлчилгээ - 3
Зориулалт: Боловсрол - 1, Соёл - 2, Эрүүл мэнд - 3

IV. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТӨСВИЙН ШИНЖТЭЙ ЗАРДЛЫН МЭДЭЭЛЭЛ*

МД	Регистрийн дугаар							Нийгмийн үйлчилгээ үзүүлэгч нэгж, цехийн нэр	Үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо	Ажиллагчдын тоо	Түүхий эд, хангамжийн материалын зардал (төг)	Үйлчилгээний зардал (төг)	Нийт цалин хөлс (төг)	Бусад зардал (төг)
	А							Б	1	2	3	4	5	6
1								___/___/___						
2								___/___/___						
3								___/___/___						
4								___/___/___						
5								___/___/___						
6								___/___/___						
7								___/___/___						
8								___/___/___						
9								___/___/___						
10								___/___/___						

* Зөвхөн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нөхнө.

Энэ бүлэгт тухайн санхүүгийн жилд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс нийгмийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэгч нэгжүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулахад гаргасан зардлыг тайлагнана

Тамга тэмдэг	Гүйцэтгэх захирал /	Нэр	/
		Гарын үсэг		
Тамга тэмдэг	Ерөнхий (ахлах) нягтлан бодогч /	Нэр	/
		Гарын үсэг		
Тамга тэмдэг-ны аудитор /	Нэр	/
		Гарын үсэг		

"Энэхүү тайланг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь зарчмын дагуу боловсруулсан бөгөөд 20... оны санхүүгийн жилийн нэгдсэн тайлан нь Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуульд зааснаар санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хийгдсэн Тус компанийн санхүүгийн нэгдсэн тайланг баталгаажуулсан аудитын байгууллагын дүгнэлтийг хавсаргав Тайлагнагч байгууллагууд, тайлангийн үнэн, зөв байдлыг хариуцна.

20... оны . . сарын . .

**АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 20...
ОНЫ ТАЙЛАН (3-ОУИТБС-1) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР**

Ашигт малтмалын олборлолт, хайгуул эрхэлдэг аж ахуйн нэгж нь дараа оны 5 дугаар сарын 15-ны дотор ОУИТБСАА-нд цахим тайлагналын системээр маягтаар ирүүлнэ. ОУИТБСАА нь 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний статистикийн хороонд нэгтгэлийг аж ахуйн нэгж, байгууллагаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

Аж ахуйн нэгжийн хуулийн албан ёсны нэрийг бичиж, регистрийн дугаарыг тавина.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлийг үнэн зөв нөхнө. Харьяалах татварын албаны нэр гэдэгт татварын байгууллагын татвараа төлдөг аймаг, нийслэл, сум дүүргийн нэрийг бичнэ. Үйл ажиллагааны чиглэлийг үндсэн үйл ажиллагаанаас хоёрдогч, гуравдагч үйл ажиллагаа гэсэн дарааллаар нөхнө.

II. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1. АШИГЛАЛТ БОЛОН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тусгай зөвшөөрлийн мэдээллийг ашигт малтмалын нэр төрөл бүрээр гаргах бөгөөд багана 1, 2, 3-ыг тусгай зөвшөөрлийн мэдээлэлд үндэслэн нөхнө. Багана 4-д тухайн ашигт малтмалын орддын оршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг болон газрын нэрийг тодорхой бичнэ. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хувьд хайж байгаа ашигт малтмалын нэр, талбайн хэмжээ, олгосон огноо, орддын оршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг болон газрын нэрийг бичнэ.

2. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.1 ТҮРШИЛТ / ХАЙГУУЛЫН ҮЕИЙН ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ

Тайлант жилд хайгуулын тусгай зөвшөөрлийн дагуу туршилтын журмаар олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нөхнө. Олборлолт, борлуулалтын биет хэмжээгээр багана 1, 3-т, мөнгөн дүнгээр багана 2, 4-т нөхнө. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг үнийн дүнгээр гаргахдаа үйлдвэрлэгчийн өртгөөр нь харин борлуулалтыг гаргахдаа худалдан авагчийн үнээр бодож нөхнө.

2.2 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

Тайлант жилд олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүний нэр төрлөөр нөхнө. Олборлолт, борлуулалтыг биет хэмжээгээр багана 1, 3-т, үнийн дүнгээр багана 2, 4-т нөхнө.

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг үнийн дүнгээр гаргахдаа үйлдвэрлэгчийн өртгөөр, харин борлуулалтыг гаргахдаа худалдан авагчийн үнээр гаргана. Бүтээгдэхүүний кодыг дараах хүснэгтээс харж нөхнө.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН АНГИЛАЛ

Код	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Код	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж
1101000	Чулуун нүүрс	мян т	1429033	Молибдений баяжмал, 47%-ийн агуулгад шилжүүлснээр	мян.тонн
1102000	Брикет, шахмал нүүрс	мян.т	1429041	Цагаан тугалганы хүдэр	мян.тонн
1103000	Хүрэн нүүрс	мян т	1429042	Цагаан тугалганы баяжмал	тонн
1105000	Хүлэр	мян т	1429051	Хар тугалгын хүдэр	мян.тонн
1201000	Газрын тос	барр.	1429052	Хар тугалгын баяжмал	мян.тонн
1202000	Байгалийн хий (хий болон шингэн)	мян.м3	1429090	Бусад төрлийн хүдэр ба баяжмал	мян.тонн
1203000	Байгалийн битүм, шатдаг занар,	тонн	1511000	Занар	тонн
1300000	Уран болон торийн хүдэр, тэдгээрийн баяжмал	тонн	1512010	Гантиг	мян.м3
	Төмрийн хүдэр	мян.тонн	1512020	Барилгын шохойжсон чулуу	мян.м3
1410000	Төмрийн хүдэр баяжмал	мян.тонн	1513010	Боржин	мян.м3
	Төмрийн бүхэл баяжмал /хүдэр/	мян.тонн	1513020	Хөшөөний чулуу	мян.м3
	Төмрийн нунтаг баяжмал /хүдэр/	мян.тонн	1513030	Үерийн чулуу	мян.м3
1421010	Зэсийн хүдэр	тонн	1513090	Гантиг, барилгын шохойжсон бусад	мян.м3
1421020	Зэсийн баяжмал, металл агуулгаараа	тонн	1520020	Шохойн чулуу	мян.тонн
1421030	Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр	тонн	1531000	Байгалийн элс	мян.м3
1422000	Никелийн хүдэр, баяжмал	тонн	1532010	Буталмал чулуу	мян.м3
1423000	Хөнгөн цагааны хүдэр, баяжмал	мян.тонн	1532020	Хайрга, шороо	мян.м3
1424010	Мөнгөний хүдэр	кг	1532030	Дайрга	мян.м3
1424020	Мөнгөний баяжмал	кг	1533000	Байгалийн лав (битум), цардас	тонн
1424040	Алг	кг	1540000	Шавар	мян.м3
1429011	Цайрын хүдэр	мян.тонн	1612000	Хайлуулаагүй төмрийн пирит	тонн
1429012	Цайрын баяжмал	мян.тонн	1619010	Хайлуур жонш	мян.тонн
1429021	Гянтболд/вольфрамын хүдэр	тонн	1619020	Хайлуур жоншны баяжмал	мян.тонн
1429022	Гянтболд/вольфрамын баяжмал	тонн	1620090	Давс	мян.тн
1429031	Молибдений хүдэр	мян.тонн	1633000	Шохой болон гөлтгөнө (доломит)	мян.тн
1429032	Молибдений баяжмал, металл агуулгаараа	мян.тонн	3754012	Тоосго	мян.ш

2.3 НӨХӨН СЭРГЭЭСЭН ТАЛБАЙН МЭДЭЭЛЭЛ

Тайлант жилд нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг тусгай зөвшөөрөл тус бүрээр гаргах бөгөөд багана 1-д нөхөн сэргээсэн талбайн хэмжээг, багана 2-д нөхөн сэргээлтийн үе шатыг техникийн эсвэл биологийн гэж ангилан, багана 3-д зарцуулсан зардлыг мөнгөн дүнгээр нөхнө

3. УЛСЫН ТӨСӨВТ ТӨЛСӨН АЛБАН ТАТВАР, ТӨЛБӨР, ХУРААМЖ, НОГДОЛ АШИГ

Энэ хэсэгт зөвхөн улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашгийг маягтад бичсэн төрөл ангиар ялган нягтлан бодохын мөнгөн суурьтай үнэлгээгээр гаргана.

3.1 АЛБАН ТАТВАР

3.1.1 АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР: Аж ахуйн нэгжийн тухайн жилийн төлсөн татварыг бичнэ. Энэ татварт дараах орлогоос төлсөн татвар орно. Үүнд:

- Ногдол ашгийн орлого,
- Эрхийн шимтгэлийн орлого,
- Хүүгийн орлого,
- Эрх борлуулсны орлого,
- Гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлсэн ашиг,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн зээлийн хүүгийн болон батлан даалт гаргасны төлбөр,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого,
- Удирдлагын зардалд төлсөн төлбөр,
- Түрээсийн төлбөр,
- Биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого зэрэгт ногдуулсан татварыг оруулан тооцож бичнэ.

Орлогын албан татварыг бусад татварын илүү төлөлтөөр суутгал хийсэн бол татварын суутгалын тооцоог тусад нь хавсаргана.

3.1.2 ГААЛИЙН АЛБАН ТАТВАР: Зөвхөн гаалийн татварыг дангаар нь оруулна. Гаалийн татвартай хамт нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөн бол түүнийг гаалийн албан татварт оруулахгүй тусад нь салгаж, 3.1.3-т хамааруулна

3.1.3-3.1.5-т заасан татварыг төлсөн бол тохирох мөр, баганад нөхнө

3.2 ТӨЛБӨР, ХУРААМЖ, НД-ЫН ШИМТГЭЛ

3.2.1 АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР БОЛОН НЭМЭЛТ ТӨЛБӨР: Тухайн жилд төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөрийг тусгай зөвшөөрөл тус бүрээр нөхнө. Хэрэв тухайн аж ахуйн нэгж 3 болон түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа бол нэмэлт мөрөөр мэдээллэнэ.

3.2.2 АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН БОЛОН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨР: Тухайн жилд төлсөн ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг тусгай зөвшөөрөл тус бүрээр нөхнө. Хэрэв тухайн аж ахуйн нэгж 3 болон түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа бол нэмэлт мөрөөр мэдээллэнэ.

3.2.3-3.2.4 Тухайн жилд улсын төсөвт төлсөн төлбөр нэг бүрээр нөхнө

3.2.5 АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨР гэж тухайн аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаандаа агаарын бохирдуулсанд төлсөн төлбөрийг ойлгоно. Зөвхөн нүүрс олборлодог аж ахуйн нэгжүүд нөхнө.

3.2.6 АЖИЛЛАГЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ гэж тухайн аж ахуйн нэгж болон ажилтнаас нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн нийт дүнг ойлгож нөхнө.

3.2.7 ГААЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ. Энд экспорт, импортын гаалийн бүрдүүлэлт хийсэн үйлчилгээний хураамжийг хамруулна.

3.2.8 ТӨРИЙН ӨМЧИЙН НОГДОЛ АШИГ. Төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчийн аж ахуйн нэгжийн тухайн жилд төлсөн ногдол ашиг багтана. Энэ хэсэг нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоогүй, төрийн байгууллагатай ногдол ашиг өгөх гэрээ хийгээгүй аж ахуйн нэгжид хамаарахгүй.

3.2.9-3.2.10 ЗАСГИЙН ГАЗАРТ ТӨЛСӨН УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР. Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөрүүд болон цөмийн энергийн тухай хуулийн 5.2, 5.3-д заасны дагуу Засгийн газарт ногдох орлогын дүнг бичнэ.

3.3 БУСАД. Маягтын 3.3.1-д төлсөн бүх төрлийн торгууль, 3.3.2-д нөхөн төлбөрийг бичнэ.

3.3.3 БО-НЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ДАНСАНД ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЗАРДЛЫН 50 ХУВИЙН ХЭМЖЭЭ. "Ашигт малтмалын тухай" Монгол Улсын хуулийн 39.1.9-д заасны дагуу байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан дүнг бичнэ.

4. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ӨГСӨН ХАНДИВ, ДЭМЖЛЭГ: Аж ахуйн нэгж, байгууллагаас яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, бусад төрийн байгууллагад өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэгийг нөхнө.

Хандив өгсөн байгууллагын нэрийг багана А-д нөхнө.

Байгууллагын төрөл нь яам бол 1, агентлаг бол 2, аймаг бол 3, нийслэл бол 4, сум бол 5, дүүрэг бол 6 гэж багана Б-д нөхнө.

Хэлбэр нь мөнгөн бол 1, мөнгөн бус бол 2 гэсэн кодыг нөхнө. Биет хэлбэр (мөнгөн бус)-ээр өгсөн хандив, дэмжлэгийг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр үнэлнэ

Төрөл нь бэлэг бол 1, хандив бол 2, хариу төлбөргүй үйлчилгээ бол 3 гэсэн кодыг нөхнө.

Зорилг-ыг тодорхой бичнэ.

Зориулалт нь боловсролын үйл ажиллагаанд бол 1, соёлын арга хэмжээнд бол 2, эрүүл мэндийн үйл ажиллагаанд бол 3 кодыг нөхнө. Хандив, дэмжлэгийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлж, багана 1-д нөхнө

III. САЙН ДУРЫН МЭДЭЭЛЭЛ

6.1 ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ОРЛОГООС АЛБАН ТАТВАР СУУТГАЖ ТӨЛСӨН ДҮН-г нөхнө

6.2-6.5-д хамаарах хууль тогтоомжийн дагуу төлсөн хураамжийг энд нөхнө.

6.6-6.8-д хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжээс нутгийн захиргааны байгууллагад тухайн жилд төлсөн хураамж, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж, нутгийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс гэж салган зохих мөрөнд нөхнө.

6.9 ЯАМ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ТӨЛСӨН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ-д дараах төлбөрийг хамааруулна Үүнд:

-Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрлийн хураамж,

-Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн хураамж,

-Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрлийн хураамж,

-Тусгай зөвшөөрөл шаардагдах үйлдвэрлэл, үйлчилгээний зөвшөөрлийн хураамж,

-Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хураамж,

-Замын цагдаагийн газарт төлсөн үнэмлэхийн хураамж, үзлэгийн хураамж,

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд төлсөн тэмдэгтийн хураамж,

-Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт төлсөн лавлагаа гаргуулсны хураамж.

6.10 ЯАМ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛЧЛЭЛЭГД ТӨЛСӨН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС-д дараах төлбөрийг хамрааруулна Үүнд:

-Тусгай зөвшөөрөл авах, шилжүүлэх, барьцаалах, сунгуулах, талбайг буцаан хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлэх, үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг нөхөн олгох зэрэг үед өргөдлийг хянан үзэх үйл ажиллагааны үйлчилгээний хөлс,

-Холбогдох байгууллагад жин баталгаажуулалтын хөлс, хэмжилтийн хөлс,

-Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон гадаад иргэдийг олон удаа орох гарах өмчийн хуудас, үйлчилгээний хөлс, оршин суух зөвшөөрөл, тодорхойлолтын үнэ, хөдөлмөр эрхлэлтийн урилга,

-Ашигт малтмалын газарт лицензийн үйлчилгээний төлбөр, бүртгэлийн төлбөр, тайлангийн үйлчилгээ, геологийн багц мэдээллийн хөлс, талбайн захиалгын захиргааны хөлс, лиценз худалдан авах үйлчилгээний хөлс, тайлан хянуулах хөлс,

-Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тусгай зөвшөөрлийн хөлс,

-Усны хэмнэлтийн төвд төлсөн үйлчилгээний хөлс,

-Сорьцын албанд сорьцын шинжилгээний зардал,

-Стандарт хэмжил зүйн төвд нарийн хэмжүүрийн хөлс, стандартын үйлчилгээний хөлс,

-Татварын албанд зөвшөөрлийн хөлс зэрэг болно

6.11 ГАДААДЫН АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ-д төлсөн үйлчилгээний хураамжийг нөхнө.

6.12 ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ, АШИГЛАСНЫ ТӨЛБӨР. Тухайн жилд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийг нөхнө

6.13-6.18 Тухайн аж ахуйн нэгж

-Гэрээ, тодорхой нөхцөлөөр хөнгөлүүлсэн, чөлөөлсөн татвар

-Хөрөнгө оруулалтын зардал

-Ажиллагчдын сургалт чадавч бэхжүүлэхэд зориулсан зардал

-Геологи, хайгуулын зардал

-Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын дүнг тухайн жилд байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал

-Гамшгаас хамгаалахад зориулсан зардал (Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу)-ыг нөхнө.

7. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭН, БУСАД БАЙГУУЛЛАГАД ӨГСӨН ХАНДИВ, ДЭМЖЛЭГ

Төрийн бус байгууллага, бусад аж ахуйн нэгж, иргэд, бусад байгууллагад өгсөн бүх төрлийн мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэгийг нөхнө. Хандив хүлээн авсан байгууллагын нэрийг багана А-д нөхнө.

Хандив, дэмжлэг хүлээн авагчийн төрөл нь төрийн бус байгууллага бол 1, бусад байгууллага бол 2, иргэн бол 3 гэж багана Б-д нөхнө.

Хэлбэр нь мөнгөн бол 1, мөнгөн бус бол 2 гэсэн кодыг нөхнө. Биет хэлбэр (мөнгөн бус)-ээр өгсөн хандив, дэмжлэгийг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр үнэлнэ.

Төрөл нь бэлэг бол 1, хандив бол 2, хариу төлбөргүй үйлчилгээ бол 3 гэсэн кодыг нөхнө.

Зорилго-ыг тодорхой бичнэ.

Зориулалт нь боловсролын үйл ажиллагаанд бол 1, соёлын арга хэмжээнд бол 2, эрүүл мэндийн үйл ажиллагаанд бол 3 кодыг нөхнө. Хандив, дэмжлэгийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлж, багана 1-д нөхнө.

IV. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТӨСВИЙН ШИНЖТЭЙ ЗАРЦУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн шууд харьяаны нийгмийн үйлчилгээ үзүүлэгч салбар, нэгж, цехэд ажилчдын амралтын газар, хүүхдийн цэцэрлэг, дунд сургууль, тусгай мэргэжлийн коллеж, соёлын ордон нөхөн сэргээх эмнэлэг, спорт чийрэгжүүлэлтийн клуб, цэвэр, бохир усны систем, тээвэр зэрэг үйлчилгээ багтана

Түүхий эд, хангамжийн материалын зардалд дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэгдэх бүтээгдэхүүн (цахилгаан, дулаан, ундны ус, шатахуун, шатах тослох материал гэх мэт)-үүд орно.

Үйлчилгээний зардалд бусдаар үйлчлүүлсэн үйлчилгээний зардал (урсгал засвар, томилолт, тээврийн зардал, шуудан, холбоо, интернетийн төлбөр, банк санхүүгийн үйлчилгээний зардал, зээлийн хүү, барилга, машин тоног төхөөрөмжийн түрээс, зар сурталчилгаа, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт)-ууд орно.

Нийт цалин хөлсөнд ажиллагчдад олгосон үндсэн цалин, мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн шагнал, урамшуулал, тусламж, дэмжлэг, аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл орно.

Бусад зардалд үндсэн хөрөнгийн элэгдэл, хандив, тусламжийн зардал, ногдол ашгийн зардал, торгуулийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз зэрэг орно.

Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын

санаачилгын ажлын алба

Утас: (976)-70110525, Факс: (976)-70110155